



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 551

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хөрөнгөд бүртгэлтэй, нийт 316,716,000.00 (гурван зуун арван зургаан сая долоон зуун арван зургаан мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгө (дэд өртөө)-ийг "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийд балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга Д.Загджав, "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захидал Р.Дагдан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Дэд өртөөнд хамаарах газрын эзэмших, ашиглах эрхийг шилжүүлэх, баталгаажуулах арга хэмжээ авах;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

D.Naran

Д.НАРАНГЭРЭЛ

132001508

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 1 дугаар сарын 25-ны өдрийн
537 дугаар тогтоолын хавсралт

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
"УБЦТС" ТӨХК-Д БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, төрөл, байршил	Ашиглалтад орсон он	Тоо ширхэг	Хэмжих нэгж	Балансын нийт үнэ (төгрөг)
1	Гадна цахилгаан хангамжийн дэд өртөө (дунд төвөгшилтэй ангиллын 10/0.4 к-ийн 2*800 кВА, Хан-Уул дүүргийн 11-р хороо)	2020	1	ш	316,716,000.00
	Нийт дүн				316,716,000.00 (гурван зуун арван зургаан сая долоон зуун арван зургаан мянган)